



МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК ХК

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 4.

Улаанбаатар хот

“МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Монгол секвритиес ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурал 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, “22-р БААЗ” ХК-ийн байранд болов.

Хуралд :

- Монгол секвритиес ҮЦК ХК 106 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т.Эрдэнэбаатар 1 000 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Л.Гүндэгмаа 75 800 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- З.Номундарь 300 922 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- “22-р БААЗ” ХК 100 000 ширхэг хувьцааны саналаар /Гүйцэтгэх захирал/
- Т.Зоргитбаатар 100 000 ширхэг хувьцааны саналаар / өөрийн биеэр /
- З.Туяа 50 000 ширхэг хувьцааны саналаар / өөрийн биеэр /

627 828 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 2,09 хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Хурлыг: Л.Гүндэгмаа удирдав.

Хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг уншиж танилцуулав.

Хурлаар:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
2. Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
3. Санхүүгийн тайланд хийсэн аудитийн дүгнэлт.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
5. Бусад

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Баярсайхан ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 2,09 % байгаа тул Монгол улсын компанийн тухай хуулийн 69.3-д заасны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөр бус гэж үзэж байна.

Хурал 13 цаг 05 минутанд эхлэв.

Хурлын дарга Л.Гүндэгмаа : Ирц хүрээгүй ч гэсэн хэлэлцэх асуудалууд дээрээ ярилцаад саналаа өгөх нь зүйтэй.

3.Туул: Компанийн ихэнх хувь эзэмшигч яагаад ирэхгүй байгаам бол? Энэ компанид санаа зовдоггүй юм болов уу?

Л.Гүндэгмаа: Одоогоор хэлж мэдэхгүй байна, ямар ч байсан компанийн зүгээр бүхий л зар, мэдээлэл явуулж байна, Email болон шуудангаар бүх зарыг явуулсан.

Т.Эрдэнэбаатар: Энэ чигээрээ явсаар байвал компанид хохиролтой. Тиймээс хуулийн байгууллагаар шийдүүлэх хэрэгтэй.

Л.Гүндэгмаа: Бид хуулийн байгууллагад хандсан байгаа. Одоо хуулийн байгууллагаас л хариу хүлээж байна.

Өөр санал хэлэх хүн гарсангүй. Ингээд хувьцаа эзэмшигчдээс дахин ээлжит бус хурал зарлаж, шийдвэр гаргахаар тохиров.

ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Л.ГҮНДЭГМАА

З.ОЮУНБИЛЭГ